



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/248

Мандалговь

“Хүрэнжинсны Овоо” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 33 дугаар зүйл 33.5, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн А/195 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сайнцагаан сумын 18-р байрны гадна фасадны засвар” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Хүрэнжинсны Овоо” ХХК-тай 139,030,033 /нэг зуун гучин есөн сая гучин мянга гучин гурав/ төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зураг, төсвийн дагуу Сайнцагаан сумын 18-р байрны гадна фасадны засварын ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Мастертөсөл” ХХК-ний захирал (Б.Цэдэнжигмэд)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Сайнцагаан сумын Засаг дарга, Мандалговь хотын захирагч (С.Бат-Оргил), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4262111-5